

алхамууд бөгөөд бидэнд зорих зорилго, хийх ажил их байна. Юуны түрүүнд дараах ажлуудад анхаарлаа хандуулах шаардлагатай.

1. Мэргэжлийн хөтөлбөрийг шинэ нэр, индексээр, БШУЯ-наас батлагдан гарах хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу чанартай боловсруулах, боловсруулалтад сонирхогч тал буюу агентлаг байгууллага, төгсөгч, багш, суралцагчдыг татан оролцуулах нөхцлийг бүрдүүлэх

2. Мэргэжлийн хөтөлбөрүүдийн агуулгыг эрх зүйн шинэчлэл буюу хууль сахиулагчдын үндсэн чиг үүрэг, үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэх. Тухайлбал хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, үндэсний эрх ашгийг хангасан хууль сахиулах үйлчилгээ үзүүлэх хандлагыг хөтөлбөр бүрийн зорилгод тусгах, шаталсан сургалтын түвшин бүрт хэрэглээний болон академик агуулгын харьцааг оновчтой тогтоох

3. ХСИС-ийн үндсэн чиг үүрэг буюу сургалтын үйл ажиллагааны чанар, стандартыг баталгаажуулах, чанараа тасралтгүй сайжруулах стратеги, бодлого, процедураа боловсруулан албажуулж, олон нийтэд нээлттэй, сонирхогч бүх талуудын оролцоог хангасан дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэн, хөгжүүлэх

4. Хууль сахиулах чиглэлийн боловсролын


асуудлаар олон улсын байгууллага, нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллаж, олон улсад танигдах зэрэг саналтай байна.

Ашигласан эх сурвалж

1. U.S. Department of Labor, Bureau of Labor Statistics, *Occupational Outlook Handbook*, <http://www.bls.gov/ooh/Protective-Service/Police-and-detectives.htm> (accessed December 6, 2012).
2. National Center for Educational Statistics, *Tuition Costs of Colleges and Universities*, under "Fast Facts," <http://nces.ed.gov/fastfacts/display.asp?id=76> (accessed December 6, 2012).
3. Robert Friedman, "University Perspective: The Policing Profession in 2050," *Police Chief*, August 2006.
4. Higher Education and Local Law Enforcement By Susan Hilal, Ph.D., and James Densley, Ph.D. 5/7/2013
5. Профессиональная подготовка руководящих кадров полиции в странах европы: особенности и тенденции развития., Кобозев А.А., Монгуш А.С.
6. <http://www.uis.unesco.org/Education/Documents/iscsd-37c-fos-review-222729r.pdf>, Пересмотр Международной стандартной классификации образования: области образования и подготовки (МСКО-Ф)

ХСИС-ИЙН ДИДАКТИКИЙН ШИНЭЧЛЭЛ: ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

DIDACTICS REFORM OF LAW ENFORCEMENT UNIVERSITY: METHODOLOGY TO DEVELOP EVALUATION ASSIGNMENT



Т.Азжаргал. ХСИС-ийн Ерөнхий Эрдмийн Сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

Azjargal.T. Lecturer of Public Administration Faculty, Institute of General disciplines, Law Enforcement University, Senior Lieutenant

Abstract: Education policies of the universities and institutes focus toward implementing appeals of "New study" method and it has spent considerable time since "rules and tools" of subsequent occupation and preparation to other sectors of life have become contemporary high education trend of the world more than a method that teacher provides education and knowledge to students. The reason is that at present educational training which can hold balance between "science orientation" and "practical orientation" occupies the significant position.

Throughout Mongolia, an appeal which means "Reform of legal sector could be a complex reform" is implemented and accordingly a complex reform to be implemented in its structural and institutional level is still continued by a curriculum reform of the Law Enforcement University. Therefore at present, we need to conduct

training which can answer the below question “How is the Employability of our alumnus?” not “How many of our alumnus are employed?” This means Employment vs Employability. In other words a trend which can provide students with professional complex abilities is a very important issue and we consider it can be started from a module assessment.

ХЗЯ-ны 2014 оны ажлын төлөвлөгөөний 7 дугаар сард хийгдэх ажлын жагсаалтанд ХСИС-ийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн батлах ажил төлөвлөгдсөн байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, судалгаан дээр сурилсан хичээлийн болоод сургалтын хөтөлбөр төлөвлөгөө сургуулийн хөгжлийн гол гарц болох юм. Энэ сургуулийн үйл ажиллагааны хүрээнд яригдах боловч нэгж хичээлийн хөтөлбөрийг тэнхим, багш л төлөвлөнө. Иймээс Сургуулийн хөгжлийн гарц бол багшийн кариерийн төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэх хэрэглэгдэхүүн, арга зүй, технологийн шинэчлэлээр илрэн гарна. Багшийн үйл ажиллагаанд суралцагчид сургуулийн сургалтын чанарт ажил олгогчид үнэлгээ өгнө. Тэгэхээр урвуу хамаарлаар багш суралцагчийн ямар гүйцэтгэлд А үнэлгээ өгдөг, ямар гүйцэтгэлд В үнэлгээ, ямар гүйцэтгэлд С, D, F үнэлгээ өгч байна вэ гэдгээр сургуулийн сургалтын чанар тодорхойлогдоно. Энэ теоромыг сургуулийн дидактикийн шинэчлэлтэй холбохыг зорилгоо.

Нэг. Дээд боловсролын дэлхийн чиг хандлага:

Дээд боловсролын дэлхийн чиг хандлага нь “Боловсрол, сургалтын чанар, чанарын баталгаа, хөгжил дэвшил” гэсэн уриан доор явагдаж байна. Дээд сургуулийн сургалтын чанарт дэмжлэг үзүүлэх асуудал 1990-ээд оноос Higher Education Accreditation (Улс, тив, олон улсын, боловсролын магадлан итгэмжлэл)-ээр дамжиж хийгдэж эхэлсэн.

Дээд боловсролын чанар баталгаанд олон улсын үнэлгээ хийснээр /International Network for Quality Assurance in Higher Education/ шаталсан сургалтын хэлбэрт шилжсэн бөгөөд Германд 1990-ээд оноос боловсрол судлалд тулгарч буй бэрхшээл ба туршлага дээрээ тулгуурлан \humboldtsche “Idee der Universitaet”\ их сургууль байгуулсан.

Олон улсад 2009 оноос бакалаврын ба магистрын түвшний сургалтанд тавигдаж буй шинэ шаардлага, стандартыг боловсруулж дээд боловсролд нэвтрүүлж эхэлсэн. \Neue Anforderungen an die Lehre in Bachelor und Master Studiengngen\


Үүнээс бакалаврын ба магистрын түвшний сургалтын онцлогийг тодорхойлсон.

1. Шилжилт, судалгаан дээр суурилсан, системийг бүхэлд нь хамарсан байх шаардлага тулгарсан

2. Дээд боловсрол эзэмших сургалтын бүтцийн реформ үргэлж нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөгдөж байдаг. (Bachelor and Master) Иймээс дипломын боловсролтой төгсөгчдийн магистрантурт элсэн суралцах, бакалаврын зэрэгтэй төгсөгчдийн

магистрантурын сургалтанд хамрагдах байдал нь 70-90 хувьтай байсан бол 2010 онд нийт төгсөгчдийн дийлэнх олонх нь магистрантурт суралцах болж өөрчлөлт гарсан. Энэ өөрчлөлт нь агуулгын реформтой зэрэг явагдах ёстой болсон.

Сургалтын технологийг схемчилбэл дараах байдлаар харагдана.



Боловсрол олгох **систем** сургалтын оролтоос “Input” сургалтын гаралтад “Output” баримжаалах ёстой болсон. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл: Оюутан **юуг сурах вэ?** гэдэг нь гол биш, сургалтын тодорхой түвшинд **юу чаддаг болсон** байх вэ? гэдэг нь чухал юм. Сургалтыг дээрхи зохион байгуулалтаар явуулж чадвал үр дүнд нь боловсролын систем илүү үр өгөөжтэй болж, өрсөлдөх чадвартай болно. Төгсөгчид илүү чадвартайгаар хөдөлмөрийн зах зээлд хөл тавина. Дээд боловсролын үнэлэмж нийгэмд өснө.

Бидний бэлтгэсэн мэргэжилтний ур чадвар ажил олгогчид хүлээн зөвшөөрөх байдал их чухал. Дээд боловсролын сургалтын чанарт үнэлгээ өгөх нэг субъект нь ажил олгогчид байдаг. Их сургуулийн дипломтой хүмүүсийн үнэ цэнийн бууралтын эсрэг зогсохын тулд Их, дээд сургуулиуд **“шинэ суралцахуй”** гэсэн уриа, дуудлагыг хэрэгжүүлэхэд боловсролын бодлого чиглэх, багш бид төгсөгчдөд их мэдлэг мэдээллийг олгох гэхээсээ илүү хожмын мэргэжил болон амьдралын бусад салбарт бэлтгэх “rules and tools” нь өнөөдрийн дээд боловсролын дэлхийн чиг хандлага болж байна. Учир юу вэ гэвэл **“шинжлэх ухаанд баримжаалах”, “мэргэжилд баримжаалах”**-ын тэнцвэрийг олсон сургалт чухал байр суурь эзэлж байна. Тухайлбал бидний бэлдсэн төгсөгчдийн хэдэн хувь нь ажлын байраар хангагдсан гэхээсээ илүү төгсөгчдийн маань ажил эрхлэх чадвар хэр байна вэ? \Employment vs Employability\ энэ асуултанд хариулж чадах сургалтыг бид явуулах ёстой юм. Өөрөөр хэлбэл мэргэжлийн цогц чадамжийг тухайн суралцагчид эзэмшүүлэх чиг хандлага дэлхийд ноёлж байна.

Хоёр. Монголын дээд боловсролын өнөөгийн төлөв

Монголын дээд боловсролын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох дараах бодлогын баримт бичгүүд хэрэгжиж байна.

Дээд боловсролын бодлогын баримт бичгүүд:

- Мянганы хөгжилд суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого /2008-2021/
- Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр²³⁸
- Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /ROADMAP/ 2010-2021
- Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015/

Бодлогын зорилтууд:

1. Дээд боловсролын салбарт эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.
2. Дээд боловсролын дунд хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлно.
3. Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтцийг зохистой болгоно.
4. Дээд боловсролын сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжсэн нөхцлийг бүрдүүлнэ.
5. Судалгааны чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжсэн нөхцлийг бүрдүүлнэ.
6. Оюутны суралцах нөхцлийг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
7. Багшийн ажиллах нөхцлийг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
8. Дээд боловсролын харилцаанд оролцогчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Дээрх бодлогын зорилтонд тусгагдсанаар олон цаг үеэ олсон өөрчлөлт хийгдэж, их, дээд сургуулиудын бүтцийн өөрчлөлт өнөөдөр ч үргэлжилсээр байна. Үүнээс сургалтын орчинд хийгдэх ажлууд нь нийтлэг ерөнхий зүйлийг тусгасан макро түвшний зорилтууд харагдана. Багш бидний хөгжил өөрчлөлт өнөөгийн суралцагчид, төгсөгчдөд хэзээ өгөөжөө өгч хэрэгжиж эхлэх нь зарим талаар тодорхой бус байна.

Дээд боловсролын шинэчлэлийн реформоос "хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцнэ" гэдэг нь хамгийн бидэнд хэрэгтэй цагаа олсон өөрчлөлт болж байна. Өнөөдөр бид сургалтаа үүнд л нийцүүлэхийн тулд төлөвлөж явуулах ёстой. Өөрөөр хэлбэл хувь хүний ба нийгмийн хэрэгцээг харгалзан үзэж сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулж, түүний хэрэгжилт, үр нөлөө, арга зүйг нарийн тусгах нь зүйтэй юм.

Монголын дээд боловсролын өнөөгийн байдлыг

²³⁸ "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр". УБ., 2012, /Эрдэм боловсролтой Монгол хүн, Нийгмийн аюулгүй байдал/

харахын тулд 22 их, дээд сургуулийн 47 удирдах ажилтан, 30 сургуулийн 470 багш, 30 сургуулийн 1249 оюутан, 82 ажил олгогч байгууллагын 82 удирдах ажилтан гээд нийт 1848 хүнээс Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны төсөл, хөтөлбөрийн хүрээнд авсан судалгааны тайлангаас харах боломжтой.²³⁹

Гурав. ХСИС-ийн дидактикийн шинэчлэл:

Үнэлгээний даалгавар боловсруулах арга зүй

ХСИС-ийн төгсөгчдийн ажил эрхлэх чадвар, төгсөгчид маань нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцэж байна уу, сургуулийн сургалтын чанар суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцэж байна уу гэдгийг тодорхойлж байж хөтөлбөрийн шинэчлэлийн агуулга, мэргэшүүлэх болон мэргэших хичээлийн хувь харьцаа тодорхойлогдох болов уу. Хөтөлбөрийн шинэчлэл хийгдэх нийгмийн хэрэгцээ шаардлага, төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах зорилгоор Цагдаагийн Ерөнхий газар, Баянгол дүүргийн цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1, 2, 3 дугаар хэлтсийн нийт 100 албан хаагчийг судалгаанд хамруулж үнэлэлт дүгнэлт өгөхийг зориллоо.

Ажил олгогчдоос төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах судалгаа²⁴⁰

Асуултын утга		Тоо	Хувь
Таны мэргэжил?	Эрх зүйч	86	86%
	Хуульч	6	6%
	Эдийн засагч	7	7%
	Инженер	1	1%
Таны цагдаагийн байгууллагад ажилласан жил?	1-5 жил	17	17%
	5-10 жил	25	25%
	10-15 жил	32	32%
	15-аас дээш жил	26	26%
Та ямар албан тушаалд ажилладаг вэ?	Нэгжийн дарга	7	7%
	Хэлтсийн дарга	6	6%
	Чиглэлийн ахлах	10	10%
	Ахлах байцаагч	29	29%
	Байцаагч	48	48%

²³⁹ Р.Бат-Эрдэнэ "Монгол улсын дээд боловсролын төлөв байдал" УБ., 2010 он

²⁴⁰ 2014, Цагдаагийн Ерөнхий Газар, Баянгол дүүргийн 1, 2 дугаар цагдаагийн хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3 дугаар цагдаагийн хэлтсийн 100 албан хаагчаас авсан "Ажил олгогчдоос төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах судалгаа"-ны материал

Ажил олгогчдоос төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах судалгаа²⁴¹

	огт нийлэхгүй	нийлэхгүй	зарим талаар нийлэхгүй	нийлнэ	бүрэн нийлнэ	дундаж
Шинээр ажилд орогчдын компьютер ашиглах чадвар сайжирч байна	5	7	33	28	7	17
Шинээр ажилд орогчдын харилцааны соёл сайн	1	7	43	29	3	16
Гадаадад сургууль төгсөгчдийн төлөвшил, ажилд хандах хандлага дотоодод сургууль төгсөгчдийнхөөс илүү	14	23	34	11	6	10
Шинээр ажилд орогчдын багаар ажиллах чадвар сайжирч байна	8	13	37	21	3	13
Гадаадад сургууль төгсөгчдийн ур чадвар дотоодод сургууль төгсөгчдийнхөөс илүү	15	27	36	9	2	8
Шинээр ажилд орогчдын биеэ дайчлах чадвар сайжирсан	6	25	36	14	3	13
Шинээр ажилд орогчдын гадаад хэлний мэдлэг, чадвар сайжирч байна	8	18	30	20	3	18
Шинээр ажилд орогчдын асуудал шийдвэрлэх чадвар сайжирч байна	4	23	32	20	0	17
Шинээр ажилд орогчдын ажил хэрэг төлөвлөх чадвар сайжирч байна	6	32	41	11	2	11
Шинээр ажилд орогчдын бичгийн чадвар, соёл сайжирч байна	4	18	28	16	2	7

Дээрхи асуулгаас анхаарал татсан зүйлийг дурдвал:

1. ХСИС-ийн төгсөгчид гадаадад сургууль төгссөн ижил мэргэжлийн төгсөгчдөөс мэргэжлийн ур чадвар, хувь хүний төлөвшил ажил албандаа хандах хандлага илүү гэдэг нь харагдаж байна.
2. Шинээр ажилд орогчдын бичгийн чадвар, харилцааны соёл, ажил хэрэг төлөвлөх, асуудал шийдвэрлэх чадвар, гадаад хэлний мэдлэг чадвар, биеэ дайчлах чадвар, багаар ажиллах чадвар, компьютер ашиглах чадвар сайжирч байна гэсэн асуултанд ихэнхи нь санал нийлэхгүй байна гэсэн хариулт өгсөн бөгөөд, компьютер ашиглах чадвар, харилцааны соёл, багаар ажиллах чадвар зарим талаар сайжирсан гэдэг нь судалгаанд хамрагдсан оролцогчдын хариултаас харагдаж байна.
3. Шинээр ажилд орогчдын ажил хэрэг төлөвлөх чадвар, биеэ дайчлах чадвар хангалтгүй байна, энэ асуудалтай санал нийлэхгүй байна гэдэгт судалгаанд оролцогчдын олонхи нь санал өгчээ. Мөн судалгаа авч байхад ажил олгогчид манай төгсөгчдөөс шаарддаг, төгсөгчдөд дутагддаг чадвараас дурдвал даалгавар өгөөд 1 объектыг судлаад ир гээд хоёр хүнийг явуулахад нэг нь тухайн зүйлийг судлаад ирэхэд нөгөөдөх нь тухайн объектоос гадна түүний холбоо сүлбээг хамаарал бүхий өөр бусад субьекттэй нь судлаад ирэх жишээтэй ийм бүтээлч сэтгэлгээтэй төгсөгчийг л манайхаас шаардаад байгаа нь судалгаа авах явцад ажиглагдаж байлаа.

Төгсөгчдөд дутмаг ур чадвар, төлөвшил: ажил олгогчдын төсөөлөл²⁴²

	Ур чадварууд	Давтамж	Хувь
1	Хариуцлага хүлээх чадвар	28	18
2	Мэргэжлийн ур чадвар	45	30
3	Асуудал шийдвэрлэх чадвар	17	11
4	Гадаад хэлний мэдлэг	22	14
5	Үнэнч шударга зан	11	7,3
6	Багаар ажиллах чадвар	19	12,6
7	Харилцааны соёл	13	8,6

²⁴¹ 2014, Цагдаагийн Ерөнхий Газар, Баянгол дүүргийн 1, 2 дугаар цагдаагийн хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3 дугаар цагдаагийн хэлтсийн 100 албан хаагчаас авсан "Ажил олгогчдоос төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах судалгаа"-ны материал

²⁴² 2014, Цагдаагийн Ерөнхий Газар, Баянгол дүүргийн 1, 2 дугаар цагдаагийн хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3 дугаар цагдаагийн хэлтсийн 100 албан хаагчаас авсан "Ажил олгогчдоос төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах судалгаа"-ны материал

Манай төгсөгчдөд дутмаг ур чадварыг мэргэжлийн ур чадвар, хариуцлага хүлээх чадвар, гадаад хэлний мэдлэг чадвар, багаар ажиллах гэх мэт чадварууд дутагдалтай болох нь онооны эрэмбээс харагдаж байна.

Ажил олгогчдоос санал болгож буй нэн түрүүнд шийдэх асуудал²⁴³

	ажил олгогч	Хувь
Багш нарыг чадваржуулах	37	18%
Суралцагчдад учирч буй төлбөр, хураамжийн дарамтыг хөнгөлөх	23	11,4
Амжилттай сайн үр дүнг урамшуулах хөшүүрэг бий болгох	21	10,44
Мэргэжлийн ном, хэвлэл, мэдээллийн хангамжийг сайжруулах	16	7,9
Сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлтэй нийцүүлэх	21	10,44
Сурлагын амжилт, ахиц, дэвшлийг үнэлэх тогтолцоог сайжруулах	8	3,9
Суралцах үедээ дадлагажих боломж, нөхцлийг сайжруулах	26	11,44
Суралцагчдын ахуй амьдралыг сайжруулах	3	1,4
Сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж, ашиглалтыг сайжруулах	21	10,44
Суралцагчдыг ажлын байранд зуучлах, мэдээллээр хангах	5	2,48
Сургалтын байгууллага, ажил олгогчийн холбоог сайжруулах	12	5,9
Сургууль, багш нарын тухай мэдээллийг нээлттэй болгох	8	3,9

Энэ асуулгаар нэн түрүүнд шийдвэрлэх асуудалд сургуулийн багш нарыг чадавхижуулах, сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх, суралцах үедээ дадлагажих боломж нөхцлийг сайжруулах шаардлагатай байна гэж ажил олгогчдын зүгээс төгсөгчдийн ур чадварыг үнэлж дүгнэсний үндсэн дээр өгсөн байна.

Тэгэхээр сургуулийн зүгээс багш нарыг ажлын байран дээрээ хөгжих боломж бололцоог бүрдүүлж сургалтын хэрэглэгдэхүүн, хичээлийн арга зүй, нэгж хичээлийн болоод сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлд нийцүүлэх нь нэн тэргүүний ажил болж байна. Учир нь багшийн хөгжил бол нийгмийн хөгжлөө дагаад боловсролын шинэчлэл, кррикулимийн өөрчлөлт багшийн хөгжлийг бий болгоно гэж үзэж байна.

Тиймээс ажил олгогчийн зүгээс төгсөгчийн талаар илэрхийлсэн байр суурийг үндэслэн төгсөгчдөд дутмаг ур чадварыг багшаас суралцагчийг сургах, түүнийг үнэлэх үйлийн явцад олгох боломж бололцоо байгаа эсэхийг тодорхойлъя.


Юуны түрүүнд боловсролын парадигмийн өөрчлөлт нь: Ямар чадамжтай хүн бий болгох вэ гэдгээс хамаарч хөтөлбөрөө боловсруулна. Тухайн нийгмийн хам нөхцөлд нь баримжаалсан сургалт явуулах нь өнөөдөр их чухал болсон байна. Прадигмийн шилжилт, өөрчлөлтийг доорхи дугуйгаас харж болно.



²⁴³ 2014, Цагдаагийн Ерөнхий Газар, Баянгол дүүргийн 1, 2 дугаар цагдаагийн хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3 дугаар цагдаагийн хэлтсийн 100 албан хаагчаас авсан “Ажил олгогчдоос төгсөгчдийн талаар илэрхийлсэн байр суурийг тандах судалгаа”-ны материал

Системийн өөрчлөлтийн үед багшийн ур чадвар-компетенцийн өөрчлөлтийг илэрхийлбэл: Багш бол суралцагчид насан туршийн суралцахуй буюу насан туршдаа суралцах чадварыг олгох нь чухал байна. Тухайлбал *багш мэдэхийг багшлах, бүтээхийг багшлах, амьдрахыг багшлах,*

нийгэмшихийг багшлах, нэгж хичээлийн сэдвээ өдөр дутмын амьдралд чиглүүлж байж шавь төвтэй цогц чадамжийг олгосон сургалтын процесс явагдаж, үр дүнд нь цогц чадамж бүхий төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлнэ гэж үзэж байна.



2001 оноос Austria, Belgium, Denmark, Finland, France, Germany, Netherlands, New Zealand, Norway, Sweden, Switzerland, United States гэсэн 12 оронд DeSeCo хэмээх "түлхүүр цогц чадамжийг тодорхойлоход ерөнхий бүтэцчилсэн хүрээгээр хангах, залуучууд болон насанд хүрэгчдийн цогц чадамжийг үнэлэх олон улсын судалгаа шинжилгээг хүчтэй болгох" зорилготой төсөл хэрэгжиж эхэлсэн.²⁴⁴

Цогц чадамж гэж юу вэ? Цогц чадамж нь хувь хүнд байж болох өөрөөр хэлбэл сурч болох чадвар, дадал бөгөөд тодорхой асуудлыг шийдвэрлэж чадах энэхүү чадвар дадал нь хүний сэдэл тэмүүлэл, шийдвэрлэсэн асуудлаа янз бүрийн нөхцөлд үр ашигтай хариуцлагатай ашиглах нийгмийн өмнө хариуцлага хүлээхэд бэлэн байх социол чадварыг өөртөө багтаадаг.²⁴⁵

Багшийн төлөвлөгөө:

Зорилго	Агуулга	Арга	Хэрэглэг-дэхүүн	Үр дүн / үнэлэх /
Яагаад?	Юуг?	Яаж?	Юугаар?	Юунд хүрэх вэ? / Юуг үнэлэх вэ?

Багш та өөрөөсөө доорхи асуултыг асууж үзээрэй:

1. Ямар гүйцэтгэлд "А" үнэлгээ өгдөг вэ?
2. Ямар гүйцэтгэлд "F" үнэлгээ өгдөг вэ?
3. Та хичнээн төрлийн үнэлгээний арга хэрэглэдэг вэ?

²⁴⁴ "The definition and selection of key competencies" Executive Summary

²⁴⁵ "Боловсрол судлал сэтгүүл" 2011/03 /71/

4. Оюутныг үнэлэх зорилго юу вэ?

5. Та оюутны сурлагын амжилтаар юу юуг үнэлдэг вэ?

Дээрхи багшийн төлөвлөгөөний загвар мөн практик байгууллагын албан хаагчдаас авсан төгсөгчдийн мэдлэг чадварыг тандах судалгааны үр дүнг үндэслэн, мөн дээрхи асуултанд хариулт олох үүднээс Блумын таксономийн хоёр хэмжээст хүснэгтийг хууль сахиулахын боловсролд туршиж үзье.

XIX зууны тавиад оны үед хичээл, сургалтын зорилгыг нарийвчлах талаар судалгааны түвшинд нэлээд ажлууд хийгдэж байсны нэг нь Бенжамин Блумаар ахлуулсан эрдэмтдийн боловсруулсан таксономи (1956 он) бөгөөд боловсрол судлалын практикт "боловсролын зорилгын Блумын таксономи" хэмээн нэршжээ.²⁴⁶

Блумын шинэчлэгдсэн таксономи буюу Блумын шавь Лорин Андерсоны бүрэлдэхүүнтэй судлаачдын багийн боловсруулсан /1995-2000 онд/ когнитив ай дахь Блумын таксономийг когнитив сэтгэл судлалын онолыг үндэслэн сайжруулж "Блумын шинэчлэгдсэн таксономи" хэмээх хоёр хэмжээст хүснэгтэнд тулгуурлаж сурах, сургах, үнэлэх үйл явцыг боловсронгуй болгоход чиглэж байна.

Б.Блум нь сургалтын зорилгыг буюу энэ зорилгын хүрээнд эзэмших чадварыг юуны өмнө гурван том ай (domain) болгон авч үзсэн байна. Үүнд:

1. Когнитив ай – Оюуны чадвар-Мэдлэг: Когнитив домайн нь мэдлэг болон оюуны чадварын

²⁴⁶ Lorin W.Anderson and other, A Taxonomy for Learning, Teaching and Assessing, p27-92.

хөгжилтэй холбоотой юм. Энэ нь тухайн баримтыг таних буюу давтан хэлэх, горимыг дууриах (procedural patterns) болон оюуны авъяас, чадварыг хөгжүүлэх ойлголтыг багтааж байдаг.

2. Аффектив ай – Мэдрэмж, сэтгэл хөдлөл-

Хандлага: Энэ домайн нь мэдрэмж, хүндэтгэл, талархал, урам зориг, сонирхол, хандлага гэх мэт бидний сэтгэл хөдлөлтэй холбоотой төрх байдлыг агуулна.

3. Психомоторик ай – Сэтгэц, хөдөлгөөн-

Чадвар: Бие бялдрын хөдөлгөөн, зохицуулалт болон тээврийн хэрэгсэл ашиглах чадвар зэргийг агуулна. Эдгээр чадварын хөгжил нь дадлага хийхийг шаарддаг бөгөөд хурд, нарийвчлал, орон зай, журам, гүйцэтгэх техник ур чадвар зэргээр хэмжигддэг.

Блумын шинэчлэгдсэн таксономид нэгж хичээлээр суралцагч оюуны чадвар, мэдлэг, мэдрэмж сэтгэл хөдлөл хандлага, сэтгэц, хөдөлгөөний чадварыг эзэмших ёстой гэж үзсэн бөгөөд энэ чадварыг эзэмшихдээ тодорхой оюуны когнитив үйлийн үр дүнд л баримтын мэдлэг, ухагдахууны мэдлэг; үйлийн мэдлэг, метакогнитив мэдлэг чадварыг эзэмшинэ гэж үздэг. Когнитив үйлийг дотоодод нь болон өөр хооронд нь харьцуулж когнитив үйлийн 6 зэрэглэлийг нарийвчлан 19 дэд зэрэглэлийг авч үзсэн байна.

Блумын таксономийг хэрэглэхийн ач холбогдол:

- Киррикулимыг төлөвлөх,
- Сургалтыг үнэлэх ба хүлээн авах жинхэнэ хэрэглүүр юм гэж үзэж болно.

Блумын таксономын хүснэгтийг Их Британи, АНУ-ын шилдэг сургуулиуд болон Монголын их, дээд сургуулийн физик, химийн багш нар сургалтандаа түлхүү ашигладаг, үр дүнгээ өгсөн сургалтын арга юм.

Тиймээс энэ аргыг хууль сахиулахын дээд боловсрол олгох сургалтанд ашиглаж үзвэл тухайн суралцагчийн онолын болоод практик мэдлэг чадвар дадал өөрчлөгдөнө, үүнээс үндэслээд нэгж хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт орох улбаалаад бүлэг хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт орох боломжтой гэдгийг гаргаж ирсэн юм.

Ажил олгогчийн үнэлгээ болон багшийн үнэлгээний зөрүү:

Багш нэгж хичээлийн үр дүнд суралцагчийн эзэмшсэн байх ёстой мэдлэг чадварыг тогтооцоод сургалтын үр дүнд үнэлгээ өгдөг. Энэ үнэлгээ ямар гүйцэтгэлд багш А үнэлгээ өгдөг, ямар гүйцэтгэлд В үнэлгээ, ямар гүйцэтгэлд С, D, F үнэлгээ өгч байна вэ гэдгээр сургуулийн сургалтын

чанар тодорхойлогдоно. Тиймээс ажил олгогчид төгсөгчдөөс хүсээд байгаа түвшин буюу ажил олгогчийн үнэлгээ багшийн үнэлгээ хоёрын зөрүүг гаргах үүднээс улсын шалгалтын тест, мэргэжлийн суурь хичээлийн явцын шалгалтын тестийг Блумын таксономийн хоёр хэмжээст хүснэгтэнд байршуулж үзэхэд тухайн хичээлийн тестээр суралцагчийн зөвхөн *сэргээн санах, сэргээн хэлэх, ойлгох* оюуны үйлийн тусламжтайгаар *баримтын, ухагдахууны мэдлэгийг* л шалгасан байна. Тестийн үр дүнд хэрэглэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх оюуны үйлийг хийлгэж үйлийн мэдлэг, метакогнитив мэдлэгийг шалгасан асуулт огт байсангүй.

Багш суралцагчийн эзэмшсэн мэдлэгийг үнэлэхдээ зөвхөн баримтын ухагдахууны мэдлэгийг шалгасны үндсэн дээр үнэлгээ өгөх нь маш олон ур чадвар дутагдах үндэс болж ажил олгогчид төгсөгчдийг үнэлсэн үнэлэмж сургалтын үйл явцаар нотлогдож байна.

ДҮГНЭЛТ

Мэдлэгийн болон үйлийн олон төрлөөр суралцагчийг шалгах нь төгсөгчид маань ажил олгогчийн зүгээс тавиад байгаа шаардлага, шалгуурт нийцэх боломтой гэж үзэж байна. Мөн багш суралцагчийн мэдлэгийг ингэж шалгаж байгаа юм чинь тест зохиохдоо ч энэ аргыг ашиглавал илүү боловсронгуй тест гарч ирэх юм. Эцсийн дүндээ багш сонсогчид ямар мэдлэг олгочихоод эргээд ямар мэдлэгийг нь шалгах гээд байна вэ гэсэн асуулт гарч ирнэ. Тиймээс хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөнд өөрчлөлт орох шаардлага гарна. Ингэхлээр сургалтын технологи бүхэлдээ өөрчлөгдөх боломжтой гэж үзэж байна. Үүгээр сургалтын алба ч багш нарын ажилд хяналт тавих боломжтой юм.

Уг анализаар тухайн багш заасан хичээлээрээ энэхүү хичээлийн бодлогыг боловсруулсан нэгж хөтөлбөр болон нэгж хичээлийн хөтөлбөрийг өөртөө агуулсан бүлэг сэдвийн хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлнэ. Нэгж хичээлийн хөтөлбөр нь бүлэг сэдвийн хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэхэд, бүлэг сэдвийн хөтөлбөр нь боловсролын стандартаар шаардсан үр дүнд хэрхэн хүрч болохыг илэрхийлэн, улмаар түүнийг хэрэгжүүлэхэд тус тус чиглэсэн байна гэж үзэх нь тухайн хичээл бол боловсролын стандартын үнэлгээний нэг хэсэг хэмээн үзэх үндэслэл болно.

Нийтлэг байдлаар Блумын таксономийн хүснэгтийг ашиглах загварыг тодорхойлбол: / ямар ч төрлийн үнэлгээний даалгвар зохиоход хэрэглэж болно/

Когнитив үйл							
		Сэргээн санахуй	Ойлгохуй	Хэрэглэхүй	Задлан шинжлэхүй	Үнэлэхүй	Бүтээхүй
Мэдлэгийн төрөл	А.Баримтын мэдлэг		Булаах ба дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг харьцуулна уу				
	В.Ухагдахууны мэдлэг	ЭБШХ-д зааснаар хууль ёсны зарчим зөрчигдвөл үүсэх үр дагавар	Төрийн албаны зөвлөлийн шийдвэр нь захиргааны эрх зүйн эх сурвалж болох уу?	тохируулах тест	Дараах ойлголтын аль нь алиндаа багтсан ойлголт вэ? Тойргоор илэрхийл?	Батын үйлдэл, Хүн худалдаалах гэмт хэрэг үү, биеийг нь үнэлүүлэх гэмт хэрэг үү	Сонгуулийн можаритар болон пропорциональ тогтолцооны онцлогийг тодорхойлж МУ-ын хувьд тохиромжит тогтолцоог тодорхойлно уу?
	С.Үйлийн мэдлэг	Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл бүр дээр жишээ ол		“А”-ын биеэр эдлэх ялыг тодорхойл?	Батын үйлдлийг зүйлчилж тохирох санцрыг тодорхойл?	Дээрхи үйлдэл төрийн албаны ямар зарчмыг зөрчиж байна вэ?	Булаах гэмт хэргийн тухай 1 бодлого зохионо уу?
	Д.Метакогнитив мэдлэг		ЭХ-ийн 113, 124-р зүйл ангийн зүйлчлэлийн ялгааг тайлбарла		Болд дэлгүүрт ороод энэ камертай ижил камер надад бий. Би маш хямд өгнө гээд үзэж байгаад анхаарал саринах хооронд аваад зугтаажээ. ЭХ-ийн тусгай ангийн 148, 146, 145, 147-р зүйлийн алинаар зүйлчлэх вэ?	Гэрээ гэж юуг хэлэх талаар сурах бичгээс уншиж судалж дүгнэлт гарга	

САНАЛ

1. Мэргэжлийн цогц чадамж бүхий хууль сахиулах байгууллагын албан хаагч бэлтгэхийн тулд нэгж хичээлийн үр дүн, үнэлгээнд блумын таксономийн хүснэгтийг ашиглах. Тухайлбал эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадварыг үнэлэхдээ суралцагч оюуны чадвар, мэдлэг, мэдрэмж сэтгэл хөдлөл хандлага, сэтгэц, хөдөлгөөний чадварыг эзэмших ёстой бөгөөд энэ чадварыг эзэмшихдээ тодорхой оюуны когнитив үйлийн үр дүнд л тухайлбал тэрхүү мэдлэгийг олгоходоо суралцагчаар оюуны үйл хийлгэх замаар баримтын мэдлэг, ухагдахууны мэдлэг; үйлийн мэдлэг, метакогнитив мэдлэг чадварыг эзэмшинэ гэж бодож хичээлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулах.

2. Блумын шинэчлэгдсэн таксономийг ашиглаж

хичээлийн хэрэглэгдэхүүн зохиоход цаг хугацаа багагүй зарцуулагддаг бөгөөд багшийн хөдөлмөрийг түүний зарцуулсан цагийг үнэлэх урамшуулал хөшүүргийг бий болгох. /Багшийн их хөдөлмөрийг бага үнэлгээгээр үнэлэх нь багшийг үндсэн ажлаа хийхийн тулд сургалтын бусад ажилд цаг гаргах, нэг сэдвийг заахын тулд эрдэм шинжилгээний ажил бичиж судалгааны үр дүнг суралцагчдад хүргэх, өөрийгөө хөгжүүлэх боломж бололцоог хаадаг талтай/

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. С.Батхуяг, Д.Баярмаа. “Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй” УБ., 2003 он
2. М.Баасанжав. “Дээд боловсролын хөгжлийн

- өнөөгийн байдал, зорилт” БСШУЯ, УБ., 2010 он
3. Р.Бат-Эрдэнэ нар. “Монгол улсын дээд боловсролын төлөв байдал”, УБ., 2010 он
 4. “Мянганы хөгжилд суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” /2008-2021/
 5. “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”
 6. “Дээд ба мэргэшлийн боловсролын чадавхжуулалт” /АХБ-ны төсөл/, УБ., 2010 он
 7. Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /ROADMAP/ 2010-2021
 8. “Боловсрол судлал” /сэтгүүл/ 2011/03 (71)
 9. “Боловсрол судлал” /сэтгүүл/ 2010/02/ (60)
 10. “Боловсрол судлал” /сэтгүүл/ 2010/10 (68)
 11. Lorin W.Anderson and other, A Taxonomy for learning, Teaching and Assessing, p 27-92
 12. “The definition and selection of key competencies” Executive Summary
 13. <http://en.wikipedia.org/wiki/Competence>

Хавсралт 1

Нэгж хичээлийн төгсөлтийн шалгалтын эхний 20 асуултыг Блумын шинэчлэгдсэн таксономид байрлуулахад дараах байдлаар харагдаж байна.

№	Когнитив үйл	Дэд зэрэглэл	Баримтын мэдлэг		Ухагдахууны мэдлэг			Үйлийн мэдлэг			Метакогнитив мэдлэг		
			Нэр томъёоны	Өвөрмөц, элементийн	Ангилал, зэрэглэлийн	Зарчмын, ерөнхийлөн дүгнэх	Онол, бүтэц, загварын	Алгоритмын	Техник, аргын	шалгуурын	Стратегийн	Танин мэдэхүйн	Хувийн
1	Сэргээн санах	Сэргээн таних	2		1								
		Сэргээн хэлэх	3, 4	14	11,15,17	19,20,13,7,16,18	12,10,6,8,9			5			
2	Ойлгох	Хөрвүүлэх											
		Жишээ гаргах											
		Ангилал											
		Дүгнэх, товчлох											
		Бодож гаргах, шийдвэрлэх											
		Харьцуулах											
		Тайлбарлах											
3	Хэрэглэх	Гүйцэтгэх											
		Хийж ажиллах											
4	Задлан шинжлэх	Ялгах											
		Зохион байгуулах											
		Тодруулах											
5	Үнэлэх	Шалгах, хянах											
		Шүүмжлэх											
6	Бүтээх	Шинээр дүрслэх											
		Төлөвлөх											
		Боловсруулах											

Тестээс харахад ихэнхи асуулт нь сэргээн санах, сэргээн хэлэх үйлийн тусламжтайгаар баримтын мэдлэг, ухагдахууны мэдлэгийг л шалгасан байна. Өөрөөр хэлбэл багшийн түгээсэн онолын мэдлэг, ном сурах бичигт байдаг, хуулинд заасан зохицуулалтыг

сэргээж асуусан байна. Суралцагчаар өөрөөр нь тодорхой оюуны үйл хийлгэж мэдлэг бүтээх, чадвар олгох асуулт байхгүй байгаа нь төгсөгчдийн талаар ажил олгогчийн илэрхийлсэн байр суурийг нотолж байна. Тиймээс бид арга барилаа өөрчлөх болжээ.